



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/156

Номгон

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмшигч “Гранд як” ХХК-ийн газар эзэмших эрхийн гэрчилгээг “Хаш гоёо” ХХК-д, иргэн Б.Эрдэнэтуулын газар эзэмших эрхийн гэрчилгээг иргэн Х.Долгорсүрэнд тус тус шилжүүлсүгэй.

2. Газар эзэмших эрхээ шилжүүлж байгаа болон шилжүүлэн авч байгаа иргэд, аж ахуй нэгжийн үндсэн мэдээллийг хавсралтаар баталсугай.

3. Эзэмшил газрын өөрчлөлтийг цахим системд бүртгэн цахим гэрчилгээ олгож, гэрээний биелэлтийг жил бүр дүгнэн ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл)-т, эзэмшил газраа зориулалтын дагуу зүй зохистой эзэмшиж гэрээнд заасан үүргээ биелүүлж жил бүр дүгнүүлж байхыг газар эзэмшигчдэд тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Энхбаяр)-т даалгасугай.

5. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны А/535 дугаар захирамжийн 3 дугаар хэсгийн “Гранд як” ХХК-тай холбогдох хэсгийг, аймгийн Засаг даргын 2023 оны А/189 дүгээр захирамжийг тус тус хүчингүй болгосугай.

ДАРГА



Э.ЭНХБАТ

626010413

Аймгийн Засаг даргын 2026 оны 02 дугаар сарын 13-ны
 өдрийн А/156 дугаар захирамжийн хавсралт



ГАЗАР ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ

Газар эзэмших эрхээ шилжүүлж буй								Газар эзэмших эрх шилжүүлэн авч буй иргэний мэдээлэл									
№	Ургийн овог	Эцэг эхийн нэр	Нэр	Регистрийн дугаар	Нэгж талбарын дугаар	Нэгж талбарын хаяг	Газрын хэмжээ м2	Ургийн овог	Эцэг эхийн нэр	Нэр	Регистрийн дугаар	Газрын эрхийн төрөл	Нэгж талбарын дугаар	Газрын хэмжээ м2	Нэгж талбарын хаяг	Газар ашиглалтын зориулалт	Газар эзэмшүүлэх, ашиглуулах хугацаа
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18
1	-	-	"Гранд як" ХХК	4271408	6409007999	Баянхонгор сум, Ршаант 10-р баг, Тээвэрчдийн гудамж-1, 107 тоот	5510	-	-	"Хашгоёо" ХХК	2133709	Эзэмших	6409007999	5510	Баянхонгор сум, Ршаант 10-р баг, Тээвэрчдийн гудамж-1, 107 тоот	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор	8 жил
2	Олонхууд	Батсуурь	Эрдэнэтуул	ВЭ79042166	6409012038	Баянхонгор сум, Гэгээншавь 6-р баг, Гандангийн гудамж-1, 145 тоот	30	Боржигон	Хандсүрэн	Долгорсүрэн	ВГ74012008		6409012038	30	Баянхонгор сум, Гэгээншавь 6-р баг, Гандангийн гудамж-1, 145 тоот		9 жил